

## ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын сар тутмын сонин 2017 оны 10 сарын дугаар

### Тэргүүн мэдээ

#### Цэций салхин цахилгаан станц ашиглалтад орлоо.



Говьд боссон салхин цахилгаан үүсгүүрийн турбинууд.

10 сарын 6-ны өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 50 мегаваттын хүчин чадалтай салхин цахилгаан станц ашиглалтад орж нээлтийн ёслол боллоо. ЖАЙКА-ийн сэргээгдэх эрчим хүчний салбарт хийж буй анхны долларын санхүүжилт бөгөөд (ЕСБХБ-тай хамтран олгосон зээл) Монголын “Ньюком” групп болон Японы Софт банкны “Эс Би энержи” компанийн хамтарсан хөрөнгө оруулалттай “Клин энержи Ази” компанид олгож буй төсөл юм. Энэхүү цахилгаан станц нь говийн бүс нутаг дахь анхны салхин цахилгаан станц бөгөөд Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг хангах, сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулах юм. ЖАЙКА нь Монгол Улсын эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх чиглэл баримтлан ажиллаж байна.


### Улс төр, эдийн засгийн чиг хандлага

#### У.Хүрэлсүхийн Засгийн газар байгуулагдлаа.

10 сарын 4-ний өдөр УИХ-ын намрын чуулганы нэгдсэн хуралдаанаар 47 гишүүний саналаар У.Хүрэлсүх ерөнхий сайдаар томилогдов. Ж.Эрдэнэбатын танхимын халааг авч буй эрх баригч намын дараагийн танхимын тэргүүнийг томилох санал хураалтад УИХ-ын 76 гишүүний дотроос Ж.Эрдэнэбатын Засгийн газрыг дэмжиж байсан МАН-аас сонгогдсон гишүүдээс цөөн хүн оролцсон бөгөөд нэлээн маргаан дагуулсан томилолт болов. Дараа нь Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн зүгээс УИХ-д оруулсан шинэ танхимын 15 сайдад нэр дэвшигчийг хэлэлцэн томилсноор У.Хүрэлсүхийн Засгийн газар байгуулагдав. Шинэ Засгийн газар ОУВС-ийн санхүүгийн дэмжлэгийн хөтөлбөрийг үргэлжлүүлэх байр сууриа илэрхийлж байгаа боловч багш, эмч нар цалин нэмэх шаардлага тавьж, МАН-ын доторх фракциудын зөрчил илэрч буй хүнд нөхцөл байдалд засгийн газар тогтвортой ажиллаж чадах эсэх нь анхаарал татаж байна.

### Төслийн хэрэгжилт

#### “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд төсөл боловсруулах, хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах семинар зохион байгуулагдлаа.



Оролцогчид сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлэв.

“Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах техникийн хамтын ажиллагааны төсөл”-ийн хүрээнд уг төслийн үйл ажиллагааны нэг гол чиглэл болох “Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016-2020)”-г боловсруулах, хэрэгжүүлэх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. 10 сарын 12-нд уг төлөвлөгөөнд хийх хяналт шинжилгээ ба төсөл боловсруулах аргын талаар семинар зохион байгуулагдаж БХБЯ болон НЗДТГ-ын 40 ажилтан оролцов. Семинарын үеэр ЖАЙКА-ийн богино хугацааны мэргэжилтэн Оба Цубота Японы жишээ татан хяналт шинжилгээ хийх аргын тухай лекц уншсаны дараа Workshop-ийн хэлбэрээр төсөл боловсруулах арга болон төслийн мөчлөгийн менежментийн аргад суралцав. Workshop дээр Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдийн талаар ярилцах зэргээр сургалтыг практик дээр бодитоор ашиглаж, оролцогчдын дунд сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлэв.

#### “Гал унтраах тоног төхөөрөмж болон ашиглалт, засвар үйлчилгээний байгууламжийг бэхжүүлэх төсөл”-ийн дараах хамтын ажиллагаа (Follow-up)

2003 онд буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжсэн “Гал унтраах тоног төхөөрөмж болон ашиглалт, засвар үйлчилгээний байгууламжийг бэхжүүлэх төсөл”-өөр нийлүүлсэн 17 гал унтраах машиныг НОБГ өнөөг хүртэл ашиглаж байгаа билээ. Монголд эдгээр машины оригиналь сэлбэг хэрэгсэл худалдан авах боломжгүйгээс гуравдагч орны сэлбэгийг орлуулан ашиглаж ирсэн нь техникийн ашиглалтын хугацаанд сөргөөр нөлөөлж



Нийлүүлсэн сэлбэг хэрэгсэл

байгаатай холбогдуулан ЖАЙКА ОУБ-аас Follow-up буюу төслийн дараах хамтын ажиллагаа хэрэгжүүлэн оригинал сэлбэг хэрэгсэл нийлүүлэх шийдвэр гаргасан. Энэ төслөөр худалдан авсан сэлбэг хэрэгслийн эхний хэсгийг оны 10 сарын 18-ны өдөр НОБГ-т хүлээлгэн өгсөн бөгөөд шаттай машины тоног төхөөрөмж болон бусад сэлбэг хэрэгслийг 11 сард нийлүүлж, 12 сарын эхээр хүлээлгэн өгөх ёслолын арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

### “Монгол улсын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох төсөл”-ийн 2-р шат хэрэгжиж байна.



Олон улсын татвар ногдуулалтын ахисан түвшний сургалт

2017 оны 4 сараас “Монгол улсын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох төслийн” 2-р шат хэрэгжиж эхлээд байна. Олон улсын татвар ногдуулалтын салбарт монгол улсын төсвийн эх үүсвэрийг баталгаажуулах, олон улсын хамтын ажиллагааг байвал зохих хэмжээнд нь хүргэх зорилгоор ТЕГ-ын зохион байгуулалтын бүтцийг бэхжүүлэх, байцаагч нарын хууль хэрэгжүүлэх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Монгол улсын Засгийн газар, 2017 оны 5 сард ОУВС-аас баталсан өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд Татварын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах бэлтгэл ажлыг хийж байна. Энэхүү төслийн хүрээнд эдгээр хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулахтай холбоотой зөвлөмж өгч байгаа бөгөөд энэ оны 6-р сараас татварын ерөнхий хууль зэрэг хууль тогтоомжид өөрчлөлт оруулахад чиглэсэн СЯ болон ТЕГ-ын хамтарсан ажлын хэсэгтэй тогтмол хэлэлцүүлэг хийж байна. 9 сард олон улсын татвар ногдуулалтын чиглэлээр ирээдүйд удирдах ажилтанууд болох улсын байцаагч нарт зориулан “Олон улсын татвар ногдуулалтын ахисан түвшний сургалт” (Transfer price taxation үнэ шилжүүлэлтийн татвар ногдуулалт) ыг зохион байгуулав.

### “Мал эмнэлэг, МАА-н салбарын хүний нөөцийн хөгжлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн судалгааны бүлгүүдийн ажлын үр дүнг танилцуулах хурал болов.



Үр түнгээ танилцуулж буй байдал

Техникийн хамтын ажиллагааны “Мал эмнэлэг, МАА-н салбарын хүний нөөцийн хөгжлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд 2016 оны 5 сараас мал эмнэлгийн чиглэлийн 4 байгууллага (ХААИС-ийн мал эмнэлэгийн сургууль, Мал эмнэлгийн хүрээлэн, Мал эмнэлгийн төв лаборатори, Нийслэлийн мал эмнэлгийн газар) хамтран ажиллаж, 8 сургалт, судалгааны баг байгуулсан байна. Энэ төслийн хүрээнд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулсан өргөн хүрээтэй сургалт, судалгааны сэдвээр (гахайн шүлхий, адууны ям зэрэг халдварт өвчин, үнээний фермд үржлийн технологи нэвтрүүлэхэд чиглэсэн мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах зэрэг) явагдаж буй судалгааны ажилд зориулан тоног төхөөрөмж, хэрэглээний зүйлсийг нийлүүлэн, дэмжлэг үзүүлж ирлээ. 10 сарын 12-ны өдөр эдгээр сургалт, судалгааны ажлын үр дүнг танилцуулах хурал болж, бүлэг тус бүр үйл ажиллагааныхаа үр дүнг тодотгож, энэхүү үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэхийн ач холбогдлыг тодруулав. Энэхүү төслийн хүрээнд цаашид сургалт судалгааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн хамт малын эмч нарын мэргэжил дээшлүүлэхэд анхаарах зорилт тавьж байна.

### Сайн дурын үйл ажиллагаа

### Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга. (~Шинэ жилийн яармаг худалдаа зохион байгуулна.~)



Өнгөрсөн жилийн яармаг худалдааны танхим

Шинэ жилийн баяр ойртлоо. Монголд оны эцэс болоход энэ тэнд шинэ жилийн яармаг худалаа явагдаж, гацуур мод чимэглэх эсгий хээ угалз, арьсан бүтээгдхүүн, хүүхдэд зориулсан тоглоом (Монголд шинэ жилийн өмнөх өдөр хүүхдүүдэд бэлэг өгч, гэр бүлтэйгээ шинэ жил угтах нь түгээмэл байдаг.) зардаг. Эдгээр бүтээгдэхүүний ихэнх нь монголд үйлдвэрлэсэн бөгөөд зөвхөн энэ цаг үед л зарагддаг бүтээгдэхүүн юм. Сайн дурын гишүүн Араки Шино (маркетинг/2016.3-2018.3) Монголын ЖДҮ-үүдэд бүтээгдэхүүн сайжруулах, борлуулах, сурчилгаа хийх аргыг санал болгож, байршлын талаар зааварчилгаа өгдөг. Сайн дурын гишүүн Араки Шино-гийн хамтран зохион байгуулах “Шинэ жилийн яармаг худалдаа” нь 12 сарын 2-ны (Бямба)11:00 ~ 16:00 цагт THE ENGLISH SCHOOL OF MONGOLIA-ийн зааланд (Emart-ын хойд талд байрлах) нээгдэх тул та бүхнийг хүрэлцэн ирж, оролцохыг урьж байна.

## Сайн дурын бусад үйл ажиллагааны тухай мэдээ

- 10 сарын 4 өдөр 2017 оны 2 дахь ээлжийн 7 сайн дурын гишүүн ирэв: Цүкүда Такүма (Малын үржил /ХААИС-ын Мал эмнэлгийн сургууль), Касугай Рина (Цэцэрлэгийн багш / Орхон аймгийн 9-р цэцэрлэг) , Сасай Юүина (Хөгжлийн эрхшээлтэй хүүхэд, иргэдэд дэмжлэг үзүүлэх/Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс), Савад Миса (Хөгжлийн эрхшээлтэй хүүхэд, иргэдэд дэмжлэг үзүүлэх / スジヤータシヤンド(NGO)), Сома Мадока (Гоо сайханч/Төв аймгийн мэргэжлийн сургалтын төв), Фүкүшима Мики (Байгалийн шинжлэх ухаан/ Дундговь аймгийн Боловсрол, соёлын газар), Ёшино Микико (Физик эмчилгээ / Архангай аймгийн нэгдсэн эмнэлэг)



## ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбоо

### ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбооны мод тарих үйл ажиллагаа



Мод тарихад оролцсон холбооны гишүүд

10 дугаар сарын 14-ний өдөр ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбооны санаачлагаар байгаль орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Агропарк мод тарих үйл ажиллагаа зохион байгууллаа. Энэ өдөр тус холбооны 53 гишүүн мэргэжлийн байгууллагын зааварчилгааны дагуу шар хуайс, гүйлс, чацаргана зэрэг 120 бутлаг суулгац тарив. Агропарк нь харуул манаатай, худагтай, модоо байнга услах боломжтой байдаг тул мод тарихаар тус паркийг сонгож авсан. Мөн тус паркийн урд талд байрлах ногооны талбайг ямарваа нэг байгалийн гамшгаас хамгаалах үр нөлөөг ч тооцсон байна.



Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)

Монгол дахь төлөөлөгчийн газар

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: mg\_oso\_rep@jica.go.jp